**ЗАВХАН АЙМГИЙН**
**ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2024 оны 01 сарын 17 өдөр Дугаар А/17 Улиастай

## Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Улсын нөөцийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 449 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Онцгой байдлын газрын 173 дугаар салбарын цэгүүдээс Монгол Улсын Засгийн газрын 479 дүгээр тогтоолоор 50 хувийн хямдралтай үнээр олгох малын тэжээл, 100 хувь үнэгүй олгох шатахууныг сумдад хуваарилан олгох ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

| | | |
|---|---|---|
| Ажлын хэсгийн дарга: | Д.Азжаргал | Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга |
| | Ө.Болд | Онцгой байдлын газрын дарга, хурандаа |
| | Н.Отгонжаргал | Цагдаагийн газрын дарга, дэд хурандаа |
| | Б.Чадраабал | Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга |
| | Э.Балжинням | Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга |
| Нарийн бичгийн дарга: | С.Батбаяр | Онцгой байдлын газрын 173 дугаар салбарын дарга |

2. Сумдын өвөлжилтийн цаг үеийн нөхцөл байдал, малчин өрх, малын тоо толгойн талаарх мэдээллээр ханган ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газар (Э.Балжинням)-т үүрэг болгосугай.

Захирамж-2024

8109010105

3. Хямдралтай үнээр олгох тэжээл, 100 хувь үнэгүй олгох шатахууныг холбогдох мэдээллийн дагуу хуваарь гарган батлуулахыг ажлын хэсэг (Д.Азжаргал)-т даалгасугай.

ДАРГА Г.ОНОРБАЯР